



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/185

Арвайхээр

Комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 25 дугаар тогтоолын 3.2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит байгууллагуудын худалдан борлуулах үндсэн хөрөнгөд үнэ тогтоох комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Үндсэн хөрөнгийн үнэлгээг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль, журмын дагуу сайтар зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн үндсэн хөрөнгөд үнэ тогтоох комисс (Н.Ганболд)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны “Комисс томилох тухай” А/450 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100395

Аймгийн Засаг даргын 2020 оны 04
дугаар сарын 29-ны өдрийн 1185 дугаар
захирамжийн хавсралт

ҮНДСЭН ХӨРӨНГӨД ҮНЭ ТОГТООХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: Н.Ганболд (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга)
- Гишүүд: М.Эрдэнэчулуун (аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
- М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Ц.Идэрсайхан (аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
- Б.Валя (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ерөнхий санхүүч)
- Б.Дэлгэрмаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)
- М.Мөнхбаатар (Өвөрхангай аймаг дахь Авто тээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер)
- М.Мөнхнасан (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Архив, бичиг хэрэг, нярав)